

9 ДҮГЭЭР АНГИЙН УРАН ЗОХИОЛЫН БИЕ ДААН СУРАЛЦАХ  
АЖЛЫН ДЭВТРИЙН ЗАМЫН ЗУРАГЛАЛ

| Бүлэг сэдэв                      | Ажлын хуудасны нэр  | Ажлын хуудасны дугаар | Танин мэдэхүйн түвшин |                |                |
|----------------------------------|---|-----------------------|-----------------------|----------------|----------------|
|                                  |   |                       | Мэдэх, ойлгох         | Задлан шинжлэх | Үнэлэх, бүтээх |
| Сонгодог уран зохиол-Эртний тууж | Зохиолын дүр, утга санааг ойлгон, мэдрэмж сэтгэгдлээ хам сэдэвтэй нь холбон, баримттайгаар үнэлж дүгнэх                         | 1-2                   |                       |                |                |
|                                  | Зохиолын үг сонголт, уран дүрслэл /бэлгэдэл/ -ийн учир холбогдлоор далд утгыг тайлан тайлбарлах                                 | 3                     |                       |                |                |
|                                  | Зохиолын дүрийн зорилго, зан төрх, холбоо хамаарлаас дүрийн өсөлтийг дүгнэх   | 4                     |                       |                |                |
|                                  | Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, үйл явдлын өнгөрснийг дурсах, ирээдүйг зөгнөх аргын нөлөөг тайлбарлах                           | 5                     |                       |                |                |
|                                  | Зохиолын орчин нөхцөл байдал нь сэдэв, утгыг тодруулахад нөлөөлж буйг шинжлэх   | 6                     |                       |                |                |
| Яруу найраг                      | Шүлгийн толгой, сүүл холбоц, шадын холбоцын хэлбэрүүд, /ААББ, АБАБ, АББА, АААА, АААБ/ бадаглалын онцлогийг нэгтгэн дүгнэн бичих | 7                     |                       |                |                |
|                                  | Зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдэв, хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг нэгтгэн дүгнэх                                    | 8                     |                       |                |                |

9 ДҮГЭЭР АНГИЙН УРАН ЗОХИОЛЫН БИЕ ДААН СУРАЛЦАХ  
АЖЛЫН ДЭВТРИЙН ЗАМЫН ЗУРАГЛАЛ

| Бүлэг<br>сэдэв    | Ажлын хуудасны нэр   | Ажлын<br>хуудасны<br>дугаар | Танин мэдэхүйн түвшин |                   |                   |
|-------------------|--|-----------------------------|-----------------------|-------------------|-------------------|
|                   |  |                             | Мэдэх,<br>ойлгох      | Задлан<br>шинжлэх | Үнэлэх,<br>бүтээх |
| Хүүрнэл<br>зохиол | Өгүүллэг, туурийн дүрийн зорилго,<br>зан төрх, холбоо хамаарлаас дүрийн<br>өсөлтийг дүгнэх                   | 1-2                         |                       |                   |                   |
|                   | Орчин, нөхцөл нь дүрийн зан төрх<br>болоод зохиолын сэдвийг<br>тодруулахад хэрхэн нөлөөлж буйг<br>тайлбарлах | 3                           |                       |                   |                   |
|                   | Өгүүллэгийн утга санааг гаргахын<br>тулд санаааг хэрхэн хөгжүүлснийг<br>дүгнэх                               | 4                           |                       |                   |                   |
|                   | Өгүүллэгийг уншиж, соёл, түүх,<br>нийгмийн хам<br>сэдвийн хүрээнд мэдэрч, тусган<br>хүлээж авах              | 5                           |                       |                   |                   |
|                   | Зохиолын далд утгыг тайлан<br>тайлбарлаж, хам сэдвийн<br>хүрээнд хэлэлцэн дүгнэх                             | 6                           |                       |                   |                   |
|                   | Уран дүрслэлийн учир холбогдлыг<br>нарийвчлан шинжлэх  | 7                           |                       |                   |                   |
|                   | Зохиолын үйл явдлын шугам<br>хоорондын холбоо хамаарлыг<br>тайлбарлах  | 8                           |                       |                   |                   |
|                   | Хүүрнэл зохиол -Бүлэг сэдвийн<br>үнэлгээ   | 9                           |                       |                   |                   |

## Бүлэг сэдэв: Сонгодог уран зохиол- Эртний түүж

1

Сурагчийн овог нэр.....

Эхэлсэн.....он....сар.....өдөр..... цаг

Дууссан.....он....сар.....өдөр ..... цаг

**Сэдэв: Зохиолын дүр, утга санааг ойлгон, мэдрэмж сэтгэгдлээ хам сэдэвтэй нь холбон, баримттайгаар үнэлж дүгнэх**

Агуулгын товч тайлбар

**Зохиолын дүр**- Юмны бодит байдал, түүний хувь хувийн тодорхой онцлог үзэгдэл, хэлбэрийг уран зохиолын аргаар ерөнхийлөн гаргасан тусгал.

**Мэдрэмж** - Мэдрэмж гэдэг нь харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүртэх таван мэдрэхүйгээр дамжин илрэх чадвар.

**Сэтгэгдэл**- Сэтгэсэн, сэтгэгдсэн юм буюу хүн, юм үзэгдлийн талаар төрсөн бодол, санааг сэтгэгдэл гэнэ.

**Сэдэв**- Өгүүлэгдэж буй гол юмнаас үүдэлтэй санааг сэдэв гэнэ. Өөрөөр хэлбэл эхийн гол санааг гаргахын тулд сэдэн дэвшүүлсэн санаа юм.

**Утга санаа**- Эхийн утга санаа нь зохиолч уншигчдад хандаж онцлон өгүүлсэн санаа бодол юм.

**Хам сэдэв**- Бичвэрийн дотор үзүүлсэн орон, цаг болоод нөхцөл байдлыг хам сэдэв гэнэ. Эхийн санааг ойлгох явцад уншигч сонсогчдын дурдсан танил бус үгийн хэрэглээгээр илэрнэ. Жишээ нь: нийгэм, соёл, түүх, шашин...

### Дасгал-1

Шарайголын гурван хааны төрийг авсан тавдугаар бүлэг / “Гэсэр” тууж хэсэглэлээс/

Лин оронтой зэргэлдээ байдаг Шарайгол оронд Цагаан гэрт, Шар гэрт, Хар гэрт гэж гурван хаан байжээ. Тэр цагт Шарайголын гурван хаан чуулган чуулав. Чуулгандаа цагаан гэрт цагаан гэрт хааны Цагаан эрх хатнаас төрсөн Алтангэрэлт тайжид ийм сайхан авгай хаанаас авч өгье гэж чуулган чуулуулав. “Энэ ахуйн хаадын охидыг тоолж үзье” гэв. “Хүн, морь явж хүрэхгүй” гэж цагаан харцагыг туулайн махаар бордож, “Дээд тэнгэр нарын охид сайхан уу? Үзэж ир!” гэж илгээв. Уран дуут тотийг хорхойгоор бордож, “Энэтхэгийн хааны охин сайхан уу? Үзэж ир!” гэж илгээв. Хон хэрээг муу сайн идээгээр бордож, “Төвөдийн хааны охин үнэн сайхан уу? Үзэж ир!” гэж илгээв. Чингээд тэд бүгд явав...Хон хэрээ гурван жил болтол эс ирэв. Хойд жил нь ирэв. “...За Төвөдийн газарт арван зүгийн эзэн ачит богд Гэсэр мэргэн хаанд хүрэв, би. Хатны эцэг нь Жало хаан гэнэ Гэсэр хаан эзгүй. Арван хоёр толгойтой мангаснаас Арлан гоо хатнаа авахаар нэхэж явсаар ирээгүй гэнэ. Дээд тэнгэр нар, дунд Асур нар, доор Ёусын хаад эд гурвуулын охид байх боловч Рогмо гоотой тэнцэх нь үгүй байна” гэв. Шарайголын гурван хаан Рогмо гоог булааж авах гэж байлдсан боловч амжилт муутай байв. Гэтэл Цотон ноён Шарайголын гурван хааныг тосож байлдаад олзлогдов. Цотон ноён Шарайголын гурван хаанд урваж хуйвалдаад нутагтаа ирж “Шарайголын цэргийг ухарч буцав” гэж худал хэлээд Гэсэрийн баатруудыг тараав. Шарайголын гурван хаан, Цотон ноёнттой хэлэлцэж тогтсон ёсоор гэнэт дайрч Ёин орны ноён болгов...

Алхам-1 Үгийн утгыг ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаас таамаглан бичээд, толь бичгээс утгыг мэдэж, тэмдэглээрэй. ☆

| Тайлбарлах үг | Миний тайлбар  | Толь бичгийн тайлбар |
|---------------|----------------|----------------------|
| бордож        | .....<br>..... | .....<br>.....       |
| магнаг        | .....<br>..... | .....<br>.....       |
| агт           | .....<br>..... | .....<br>.....       |
| нэхэж         | .....<br>..... | .....<br>.....       |
| тосож         | .....<br>..... | .....<br>.....       |

Алхам-2 Өөрийн таамаглалаа толь бичгийн тайлбартай харьцуулан дүгнээд өөр ямар үгээр солин найруулж болох талаар санал бичээрэй. ☆☆☆

| Тайлбарлах үг | Харьцуулсан дүгнэлт | Солин найруулж болох үг |
|---------------|---------------------|-------------------------|
| бордож        | .....<br>.....      | .....<br>.....          |
| магнаг        | .....<br>.....      | .....<br>.....          |
| агт           | .....<br>.....      | .....<br>.....          |
| нэхэж         | .....<br>.....      | .....<br>.....          |
| тосож         | .....<br>.....      | .....<br>.....          |

Зохиолын утга санааг ойлгоход үгийн утга ямар чухал үүрэгтэй байгааг дүгнэн сэтгэгдлээ бичнэ үү.


.....  
 .....  
 .....


Алхам-3 Цотон ноёны дүрээс мэдрэмж, сэтгэгдлээ тохирох хам сэдвийн хүрээнд баримттайгаар үнэлж дүгнэн бичнэ үү. ☆☆☆

Дэмжлэг: Цотон ноён ямар зан чанартай хүн бэ?, ямар үйлдлээс нь ажиглан ингэж дүгнэлт гаргасан бэ?, ноёны дүрээр нийгмийн ямар асуудлыг хөндсөн байгааг энэхүү дүртэй холбон тайлбарлаарай. /Цэнхэр өнгөөр тодруулсан хэсгээс дүгнэлт бичихдээ ашиглаарай./







Алхам-4 Зохиолын сэдэв, утга санаа дүр, дүрслэлээс мэдрэмж, сэтгэгдлээ тохирох хам сэдвийн хүрээнд баримттайгаар үнэлж дүгнэн илэрхийлээрэй. 

Дээрх 3 алхамыг гүйцэтгэж чадсан бол энэ алхамыг гүйцэтгэхэд бэлэн болжээ. Тиймээс дээрх алхмуудаа нэгтгэсэн дүгнэлт бичээрэй.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

2

Сурагчийн овог нэр.....

Эхэлсэн.....он....сар.....өдөр....цаг  
 Дууссан.....он....сар.....өдөр....цаг

**Сэдэв: Зохиолын үг сонголт, уран дүрслэл /бэлгэдэл/ -ийн учир холбогдлоор далд утгыг тайлан тайлбарлах**

Агуулгын товч тайлбар

**Зохиогчийн үг сонголт**- үгийн сан, үгсийн дуудлага, өнгө аясаараа содон үг сонгох

**Дүрслэх ур маяг** – Хэлний нэгжүүдийн шилжмэл салаа утгыг дүрслэх ур маяг гэнэ. Уран дүрслэх арга хэрэгсэл болсон зүйрлэл, адилтгал, төлөөлөл, ихэсгэл, багасгал, ёгтлол, егөөдөл зэрэг яруу хэрэглүүрийг чөлөөтэй ашигладаг.

**Бэлгэдэл**- зохиолд илүү гүн гүнзгий утга санааг илэрхийлэх зорилгоор бэлгэдлийг ашигладаг. Хэрэг явдалд хамаатай биш боловч утга, бүтцэд гүнзгий нөлөөлж, уншигчдыг чиглүүлж байдаг.

**Далд утга**- уран зохиолд өнгөн талын ил дүрслэлээр дамжуулан ямар нэгэн утга санааг далдлан өгүүлсэн байдаг. Ил биш далд өгүүлсэн утгыг далд утга гэнэ.

Дасгал-3

Арван таван насандаа арван зүгийн эзэн Гэсэр хаан гучин баатраа дагуулж умар зүг дэх уулын чинээ хар эрээн барс мангасын хувилгааныг алсан нөгөө бүлэг

Эрт цагт умар зүгт Мангасын хувилгаан уулын чинээ хар эрээн барс байжээ. Байх бие нь зуун бээрийн газрыг эзлэх ажээ. [Өндөр нь их гэсэн уулаас үлэмж их гэнэ. Сүүл нь таван зуун алдын хар болд илд шиг хоёр иртэй, ийш тийш шарвахад тэнгэрийн цахилгаанаас нэн үлэмж гэнэ.] Баруун самсаанаас нь гал мандан шатаж, зүүн самсаанаас нь утаа бургилж байна. Хүнийг хоногийн газраас үдээд үдийн газраас өрөвхийлж залгина гэнэ. Гэсэр гучин баатартайгаа явж, хүн иддэг хар эрээн барсыг алж, арьсаар нь хуяг дуулганы гэр хийв.

Алхам-1 Зохиолын энэ хэсгээс уран дүрслэл, бэлгэдлийг ялгаарай. ☆

| Уран дүрслэл                      | Бэлгэдэл                |
|-----------------------------------|-------------------------|
| Өндөр нь их гэсэн уулаас үлэмж их | Баруун самсаанаас нь... |
| .....                             | .....                   |
| .....                             | .....                   |
| .....                             | .....                   |
| .....                             | .....                   |

Алхам-2 Зохиолчийн сонгосон өвөрмөц үг, уран дүрслэл /бэлгэдэл/ –ийг ялган таньж, утгыг тайлбарла. ☆☆☆


| Зохиолчийн сонгосон өвөрмөц үг | Утгын тайлбар      |
|--------------------------------|--------------------|
| Зуун бээр                      | 200 шахам километр |
| .....                          | .....              |
| .....                          | .....              |
| .....                          | .....              |

| Уран дүрслэл                      | Утгын тайлбар  |
|-----------------------------------|--|
| Өндөр нь их гэсэн уулаас үлэмж их | Мангасын сүрдмээр дүр төрхийг гаргахын тулд адилтгаж болох хамгийн өндөр том зүйлтэй жишин түүнээс ч их, том хэмээн хэтрүүлэн дүрсэлжээ. |
| .....                             | .....  |
| .....                             | .....  |
| .....                             | .....  |

| Бэлгэдэл                | Утгын тайлбар  |
|-------------------------|--|
| Зуун алдын хар болд илд | Хар өнгөөр ид хав, хүч чадлыг бэлгэдсэн тул сүртэй, том, иртэй, бат бэх, хялбар дийлдэшгүй илд гэсэн утгыг илэрхийлж байна |



|                |                |
|----------------|----------------|
| .....<br>..... | .....<br>..... |
| .....<br>..... | .....<br>..... |
| .....<br>..... | .....<br>..... |


Алхам-3 Зохиолын үг сонголт, уран дүрслэл /бэлгэдэл/ -ээр далд утгыг тайлан тайлбарлан бичнэ үү. 

Зохиолын энэ хэсэгт утга санаагаа гаргахын тулд зохиолч бэлгэдлээр дамжуулан утгыг хэрхэн далдалсныг тайлбарлан бичээрэй.

**Далд утга:** /Санаагаа нуухыг хэлнэ/ Далд утгат үг, адилтгал, бэлгэдлээр илэрнэ.

Тухайлбал: "...Хурмаст тэнгэр ахай минь, над Шүүдрийн гилбэлгээн өнгөт **хар** хуяг өг. Цахилгаан өнгөт далавчаа өг. Нар, сар хоёрыг хамтаар зэрэгцүүлэн ургуулан хийсэн манлай **цагаан** дуулгаа өг. Оюун эрдэнэ оньт **гучин** цагаан сумаа өг. Догшин хар нумаа өг. Билгийн **гурван** алд хар шор сэлмээ өг. Дуурсахуй нэрт алтан уургаа өг. **Ерэн гурван** жингээр хийсэн их болд сүхээ өг. **Жаран гурван** жингээр хийсэн бага болд сүхээ өг. Энэ бүгдийг намайг ертөнцөд төрөхөд буулгаж өгөөрэй" гэж байна... /Гэсэр туужийн нэгдүгээр бүлгээс/

.....  
.....  
.....  
.....

Алхам-4 Зохиолын үг сонголт, уран дүрслэл /бэлгэдэл/ -ийн учир холбогдлоор далд утга /зохиолд гүн гүнзгий санаа, өвөрмөц содон санаа байна уу,/-ыг тайлан тайлбарлаарай. /Алхам 3т авсан хэсэглэлээс дүгнэлт бичих/ 

Дээрх 3 алхамыг гүйцэтгэж чадсан бол энэ алхамыг гүйцэтгэхэд бэлэн болжээ. Тиймээс дээрх алхмуудаа нэгтгэсэн дүгнэлт бичээрэй.

.....  
.....  
.....  
.....

**Сэдэв: Зохиолын дүрийн зорилго, зан төрх, холбоо хамаарлаас дүрийн өсөлтийг дүгнэх**

Агуулгын товч тайлбар

**Дүрийн холбоо хамаарал-** Нэг дүр нөгөө дүрийн нөлөөллөөс хамаарч тодорхойлогдохыг хэлж байна.

**Дүрийн өсөлт-** Тухайн дүр өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд тохиолдож буй саад бэрхшээлийг даван туулж зовлон гунигийг ялж зорилгодоо хүрэхийг хэлнэ. Харин зорилгодоо хүрч чадахгүй байвал дүрийн бууралт болно.

Дасгал-4

Алхам-1 Дүрийн зорилгыг тодорхойлоорой. 

Жангар

| Зорилго        | Зорилгодоо хүрэх арга зам | Хүрсэн үр дүн  |
|----------------|---------------------------|----------------|
| .....<br>..... | .....<br>.....            | .....<br>..... |
| .....<br>..... | .....<br>.....            | .....<br>..... |
| .....<br>..... | .....<br>.....            | .....<br>..... |

Алхам-2 Дүрийн зан төрхийг тодорхойлон дүгнээрэй. ☆☆☆

Зохиолд Жангарын холбогдолтой бусад дүрүүдийн хэлсэн үгээс эш татан түүний зан төрхийг тодорхойлоорой.

| Хэн хэлсэн | Эшлэл          | Зан төрх       |
|------------|----------------|----------------|
| .....      | .....<br>..... | .....<br>..... |
| .....      | .....<br>..... | .....<br>..... |
| .....      | .....<br>..... | .....<br>..... |


Алхам-3 Дүрүүдийн хооронд ямар холбоо хамаарал байгааг дүгнэн, үйл явдал өрнөхөд ямар үүрэгтэй байгааг тайлбарлан бичээрэй. ☆☆☆



.....  
.....  
.....  
.....  
.....

Алхам-4 Гэсэрийн дүрийн өсөлтийг ажиглан Жангар туулийн дараах хэсгээс Жангарын дүрийг зорилгоор нь өсөлтийн графикт тэмдэглэ. ☆☆☆☆☆

...Гэсэр мартсанаа сэрж, Арлан гоо хатны хамт нутагтаа ирэв. Шарайголын гурван хааныг сөнөөж, Рогмо гоо хатнаа аваад, Цотон ноёныг шийтгэж, нутаг орноо тохинуулав... /Тавдугаар бүлгээс/



|                      |                                    |                                 |                        |
|----------------------|------------------------------------|---------------------------------|------------------------|
| Гэсэр мартсанаа сэрж | Арлан гоо хатны хамт нутагтаа ирэв | Шарайголын гурван хааныг сөнөөж | Нутаг орноо тохинуулав |
|----------------------|------------------------------------|---------------------------------|------------------------|

...Тансаг бумба хааны ач  
Үйзэн алдар хааны хөвгүүн Жангар билээ  
Эрхэн хоёр насандаа  
Догшин мангаст нутгаа дайлуулж  
Өнчин биеэр үлдсэн  
Гурав хүрэх насандаа  
Аранзал зээрдийн үрээ цагт  
Хөл өргөж мордсон

Гурван их бэхлэлтийн амыг эвдэж

Гулжин шар мангасыг номдоо оруулсан

Дөрөв хүрэх насандаа

Дөрвөн их бэхлэлтийн ам эвдэж

Дөрвөн их шар мангас хааныг номдоо оруулсан...

Долоотойдоо доордын долоон орныг доройтуулж

Дуутай жангар нэрээ дуудуулсан... /Жангар туулиас/

## Жангарын дүр

|  |  |  |  |  |
|--|--|--|--|--|
|  |  |  |  |  |
|--|--|--|--|--|

3

Сурагчийн овог нэр.....

Эхэлсэн.....он....сар.....өдөр..... цаг

Дууссан.....он....сар.....өдөр..... цаг

**Сэдэв: Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, үйл явдлын өнгөрснийг дурсах, ирээдүйг зөгнөх аргын нөлөөг тайлбарлах**

### Агуулгын товч тайлбар

Зохиолд өгүүлэгдэж буй юмсыг өгүүлэгдэхүүн гэнэ. Өгүүлэгдэхүүн нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй.

|          |  |
|----------|--|
| Эхлэл    | Зохиолын өгүүлэгдэхүүний зөрчил үүсэх суурь дэвсгэр бүхий үйл явдлыг хэлнэ.                                |
| Зангилаа | Зохиолын үйл явдал үргэлжлэх, зөрчил мөргөлдөөн, үүсэх шалтгааныг хэлнэ.                                   |
| Өрнөл    | Зохиолын зангилаанаас учир шалтгааныг олохын тулд цааш үргэлжилж байгаа хэсгийг хэлнэ.                     |
| Туйл     | Зохиолын үйл явдал, зөрчил тэмцэл хурцдаж туйлдаа хүрэхийг хэлнэ.  |
| Тайлал   | Зохиолын зөрчил тэмцэл туйлдаа хүрч улмаар хэрхэн шийдэгдэж байгааг хэлнэ.                                 |
| Төгсгөл  | Зохиолын төгсгөлд баатруудын хувь заяа ямар болсон, зохиолч өөрөө хэрхэн үзсэн зэргээ илэрхийлснийг хэлнэ. |

Дасгал-5

Алхам-1 “Жангар” туулийн өгүүлэгдэхүүний бүтцийг гарга. ☆

|          |       |
|----------|-------|
| Эхлэл    | ..... |
| Зангилаа | ..... |
| Өрнөл    | ..... |
| Туйл     | ..... |
| Тайлал   | ..... |
| Төгсгөл  | ..... |

Алхам-2 Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, өнгөрснийг дурсаж, ирээдүйг зөгнөж өгүүлсэн ямар хэрэг явдал гарч байгааг тайлбарлаарай. ☆☆☆

Өнгөрснийг дурссан эшлэл-/А/, ирээдүйг зөгнөсөн эшлэлийг /Б/-үсгээр тэмдэглээрэй.

| Бүлгийн нэр                              | Өнгөрснийг дурссан /А/, ирээдүйг зөгнөсөн /Б/ эшлэл                            | Ямар зорилгоор   |
|--|--|--|
| Алтан Цээж, Жангар хоёрын байлдсан бүлэг | ...хожим хойно өөрийнх нь орыг залгаж, ертөнцийг эзлэх их хүчтэн болохыг.../Б/ | Баатар зоригтой эр болох шинжтэйд айн, сүрдэж даруй устгахаар шийдсэн. |
| .....<br>.....                           | .....<br>.....   | .....<br>.....   |
| .....<br>.....                           | .....<br>.....   | .....<br>.....   |
| .....<br>.....                           | .....<br>.....   | .....<br>.....   |
| .....<br>.....                           | .....<br>.....   | .....<br>.....   |

Алхам-3 Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, өнгөрснийг дурсаж, ирээдүйг зөгнөж өгүүлсэн хэрэг явдал зохиолын үйл явдлын өрнөлтөд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлана уу. ☆☆☆

.....  
.....

.....  
.....  
.....  
Алхам-4 Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, өнгөрснийг дурсах, ирээдүйг зөгнөх арга нь үйл явдлын цаг хугацааны дарааллыг өөрчлөхөд нөлөөлж байгааг тайлбарлаарай. ☆



Агуулгын товч тайлбар

**Зохиолын орчин-** Тухайн зохиолын үйл явдал хаана, хэзээ болж байгааг илэрхийлдэг. Орчин нь үйл явдал болж буй газар, орон байр, цаг улирал, цаг хугацаа, цаг агаарын байдал зэргээс бүрддэг.

**Нөхцөл байдал-** Дүрүүдийн хоорондын харилцааны нөхцөл байдал, дүрүүдийн үзүүлсэн орон, цагийн нийгэм, түүх, соёлын онцлогийг хэлнэ.

Сэдэв, санаа хоёр  
салшгүй холбоотой

СЭДЭВ

↓  
Зохиолчийн дэвшүүлэн  
тавьсан асуудал /нэр үгээр  
илэрнэ/

↓  
Бодит амьдрал,  
ертөнцийн юмс үзэгдэл  
/юуны тухай вэ?/

САНАА

↓  
Зохиолчийн зүгээс  
уншигчдад хэлэх гэсэн  
тодорхой санаа

↓  
Юуг илэрхийлэхийг  
зорьсон бэ?

**Сэдэв: Зохиолын орчин нөхцөл байдал нь сэдэв, утгыг тодруулахад нөлөөлж буйг шинжлэх**

Дасгал-6

Алхам-1 “Чингисийн эр хоёр загал” туужийг уншиж, сэдвийг тодрхойлоорой. ☆

.....  
.....  
.....  
Алхам-2 Зохиолын орчин/цаг, орон/-ыг шинжлээрэй. Үйл явдал хаана хаана өрнөж байна вэ? ☆☆☆

| Эхлэл хэсэг | Гол хэсэг       | Төгсгөл хэсэг |
|-------------|-----------------|---------------|
| .....       | Гурван цавчуурт | .....         |
| .....       |                 | .....         |
| .....       |                 | .....         |

Алхам-3 Бага загалын эрхэм дээд хүсэл юу байсан бэ? ☆☆☆☆

.....

.....

.....

Нутгаа сольсон орчин нь зохиолын утга санаатай хэрхэн холбогдож байна вэ? дүгнэн бичээрэй. ☆☆☆☆

.....

.....

.....

.....

.....

**Бүлэг сэдэв: Яруу найраг**

|   |                         |  |
|---|-------------------------|--|
| 4 | Сурагчийн овог нэр..... | Эхэлсэн.....он....сар.....өдөр.....цаг<br>Дууссан.....он....сар.....өдөр.....цаг |
|---|-------------------------|--|

Агуулгын товч тайлбар  
**Шад**- Шүлгийн нэг мөр  
**Бадаг**- Холбоц болон аялгын нэгэн хэмнэлд захирагдан, тодорхой утга төгссөн айзам буюу хэд хэдэн шадын нийлбэр юм.  
**Холбоц**- Шүлгийн айзам хэмнэлийг бүрдүүлж байдаг гол зүйл бол холбоц юм. Бадгийн эхлэл төгсгөл нь ижил авиагаар холбогдсон бол тэгш холбоц, бадгийн эхлэл төгсгөл нь ижил бус ойролцоо төстэй авиагаар сөөлжилж холбогдсон бол тэгш бус холбоц гэнэ. Холбоц нь дараах хэлбэрүүдтэй. Зэрэгцээ хоёр шадыг холбосон зэрэгцэх холбоц ААББ, АААА, 1 ба 3-р шад, 2 ба 4-р шадыг ижилсүүлэн холбосон салаавчлах холбоц АБАБ, 1 ба 4-р шад, 2 ба 3-р шадыг тус тус ижилсүүлэн холбосон хаших холбоц АББА байна. Монгол шүлгийн холбоц нь гол төлөв үгийн эхлэл болон төгсгөлд сонсогдоно.

**Сэдэв: Шүлгийн толгой, сүүл холбоц, шадын холбоцын хэлбэрүүд, /ААББ, АБАБ, АББА, АААА, АААБ/ бадаглалын онцлогийг нэгтгэн дүгнэн бичих**

Дасгал-7

Алхам-1 Шүлгийн сүүл хэсгийг яаж, ямар үсгээр холбосныг ажиглан тэгш, тэгш бус болохыг тодорхойлоорой. ☆

Сөнидийн Гилүгэдэй баатар магтруун:

“Халих харцагайн жигүүр **болон одов уу, чи эзэн минь**

Хангинах тэрэгний тээш **болон одов уу, чи эзэн минь!**

Туулих харцагайн жигүүр **болон одов уу, чи эзэн минь!**

Тойрох тэрэгний тээш **болон одов уу, чи эзэн минь!**

Жиргэх шувууны жигүүр **болон одов уу, чи эзэн минь!**

Жирхирах тэрэгний тээш **болон одов уу, чи эзэн минь!**" /Сөнидийн Гилүгэдэй баатрын харууслын шүлэг 1-р хэсэг/

Алхам-2 Шүлгийн толгой холбоц, /ижил буюу төсөөтэй авиа, мөн үеэр тэгш ба тэгш бус холбох/ болон шадын онцлог ямар байна вэ? ☆☆☆

...Хар буур хавирга чинээ шигдэж

Хасаг нь бул чинээ шигдэж

Хөдөлгөн ядахуйд

Таван өнгийн хөлгүүдийг хөлж гарган ядаж

Гүр улс зовохуйд

Сөнидийн Гилүгэдэй баатар мөргөн өчвэй. /Сөнидийн Гилүгэдэй баатрын харууслын шүлэг 2-р хэсэг/

.....  
.....  
.....

Энэ холбоцууд нь шүлгийг хэрхэн сонсголонтой болгож байгааг тодорхойлон бичээрэй.

.....  
.....  
.....  
.....

Алхам-3 Шүлгийн 1, 2-р хэсгийн шад, бадаглалын туршлагад дүгнэлт хийнэ үү. ☆☆☆☆

.....  
.....  
.....  
.....

Алхам-4 Энэ шүлгийн толгой, сүүл холбоц, шадын холбоцын хэлбэрүүд, /ААББ, АБАБ, АББА, АААА, АААБ/ бадаглалын онцлогийг нэгтгэн дүгнэн бичээрэй. ☆☆☆☆☆

**Жишээ нь:**

...Шаргал талын өвс халиурах **нь сайхан**

Шанхны үзүүрт салхи сэвэлзэх **нь сайхан**

Сартай шөнө бухал дээр унтах **сайхан**

Чамайг зүүдлээд газарт ойчих **сайхан**

Үе үе бороо аймсхийх **нь сайхан**



**Өлгөсөн цувнаас ус дусах нь сайхан**

**Үүлэн чөлөөнөөс нар гарах нь сайхан**

**Үүдээр болжморууд нисэн өнгөрөх нь сайхан...** /Дөрвөн цаг шүлгийн хэсгээс/

Тайлбар:

Энэхүү шүлгийн толгой холбоц нь ижил болон төсөөтэй авиагаар зэрэгцүүлэн тэгш холбосон ба сүүл холбоц нь сайхан гэсэн үгээр давтан холбосон байна. Дөрвөн цаг шүлгийн бадаглал зүйн онцлог нь нэг улирлыг 14 бадаг, бадаг бүрийг дөрвөн шадар холбон, шадын үгийн тооны айзам хэмнэл ижил болон ойролцоо байгаа нь шүлгийг сонсголонтой, айзам хэмнэлтэй болгож байна г.м.

.....

.....

.....

.....

.....

Агуулгын товч тайлбар

Хам сэдвийг хэрхэн таних вэ?

Түүхийн хам сэдэв- Түүхэн он цаг, түүхэн хүн, түүхэн үйл явдал, түүх өгүүлэх орон

Нийгмийн хам сэдэв- Аж төрөхүй, амьдрал ахуй, ард түмний амьдрал

Соёлын хам сэдэв- Бичиг, биет ба биет бус өв, эд өлгийн зүйл

Шашны хам сэдэв- Тухайн цаг үеийн ард түмний шашин шүтлэг зэргээс таньж болох юм.

**Сэдэв: Зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдэв, хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг нэгтгэн дүгнэх**

Дасгал-8

Алхам-1 “Боржигоны бор тал” шүлгийн сэдвийгтодорхойлоорой. ☆

А. Эх хүний хайр энэрэл


Б. Эх нутаг, амьдралын мөн чанар, сав шим ертөнцийн харилцаа холбоо

В. Нутгаа санасан хүү

Г. Өрөвч энэрэнгүй, сайхан сэтгэлтэй хүн

Алхам-2 Зохиолын хам сэдвийг дүгнэн бичнэ үү. ☆☆☆

|   |  |   |   |   |
|---|--|---|---|---|
| Хүн байгалийн хүйн холбоон тухай  | Хүний амьдралын тухай  | Хүний сэтгэл зүйн тухай   | .....   | .....   |
| Шүлгийн..... бадагт<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>..... | Шүлгийн..... бадагт<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>..... | Шүлгийн..... бадагт<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>..... | .....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>..... | .....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>..... |

Алхам-3 Зохиолын сэдэв, хам сэдвийг хөгжүүлснийг дүгнээрэй. 

| Шүлгийн хэсэг | Сэдэв /ямар асуудлыг хөндсөн/ | Санаа /зохиолч уншигчдад юу хэлэхийг хүссэн/                                  |
|---------------|-------------------------------|---|
| 1             | Эх хүн, эх орон               | Ээж болон эх орноо санасан сэтгэлээ илэрхийлсэн бөгөөд ээж эх орон 2 адил юм. |
| 2,3           | .....                         | .....<br>.....  |
| 4             | .....                         | .....<br>.....  |
| 5             | Төрөх жам ёс                  | .....<br>.....  |
| 6             | .....                         | .....<br>.....  |
| 7             | .....                         | .....<br>.....  |
| 8             | Үхэх жам ёс                   | Хүн эх дэлхий, байгальтайгаа хүйн холбоотой.                                  |

Алхам-4 Зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдэв, хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг нэгтгэн дүгнээрэй. 

Сурагчийн нэр: .....

Эхэлсэн: ..... он ..... сар.....өдөр



**Туурь:** Туурь бол өгүүллэгтэй ойролцоо шинж чанартай ч илэрхийлэн үзүүлэх учир шалтгаанаараа ялгаатай. Учир нь туурь хурц зөрчил, хураангуй өгүүлэмж, үйл явдлын эргэлт бүхий уран тайлалтай байдаг.

**Дүр:** Уран зохиолын дүр гэдэг бол зохиогчийн уран сэтгэмж мөн бодит байдлын уран дүрслэлээс төрдөг бөгөөд үнэн хэрэгтээ цаасан дээр буусан хүн төрөлхтөн гэж ойлгож болно.

1

**Дасгал 1 Б. Ринчений “Нууцыг задруулсан захиа” туурийн гол хэсгийг уншиж, дүрүүдийн үг, үйлдлийг харьцуулан дүгнэе.**

**Алхам 1. Гөлөгдэй баатрын хэлсэн үг, үйлдлээс зорилгыг нь тодорхойлсныг ажиглан Фү жанжны зорилгыг тодорхойлно уу.**

| Хэлсэн үг   | Хийсэн үйлдэл                                     | Зорилго                               |
|---|---|---------------------------------------|
| Үйл явдлын дүрслэл  | Заримдаа өнжин шатар нүүдэг боллоо.               | 1. Фү жанжны итгэлийг олох            |
| Үйл явдлын дүрслэл  | Төрсөн өдрийн найрт урьсан                        | 2. Фү жанжныг нууц аргад оруулж дарах |
| Миний өвгөд дээдсийн гал голомт залгамжлах ганц хүүгийн минь амийг хэлтрүүлмүй... | Фү жанжны өөдөөс хариу юу хэлэхийг ширтэн хүлээв. | 3. Шунуг амьд үлдээх                  |

**Фү жанжин**

| Хэлсэн үг | Хийсэн үйлдэл | Зорилго |
|-----------|---------------|---------|
| .....     | .....         | .....   |
| .....     | .....         | .....   |
| .....     | .....         | .....   |
| .....     | .....         | .....   |

Дууссан: .....он .....сар өдөр

**Гөлөгдэй баатар**

| Зорилго | Зан чанар  |
|---------|--|
| 1       | Ухаантай, уйгагүй, нөхцөл байдлыг зөв дүгнэж шийдвэр гаргах чадвартай. |
| 2       | Уран аргатай, холч ухаантай, тэвчээртэй                                |
| 3       | Учирч болох эрсдлийг тооцдоггүй итгэмтгий                              |
| 4       | Хатуужилтай, холч ухаантай, баатарлаг зоригтой                         |

**Фү жанжин**

| Зорилго | Зан чанар |
|---------|-----------|
| 1       | .....     |
| 2       | .....     |
| 3       | .....     |
| 4       | .....     |

**Алхам 3. Дүрүүдийн давуу болон сул талыг баримтаар батлан бичээрэй.**



**Алхам 4. Зохиолч дүр бүрээр уншигчдад юу хэлэхийг хүсэв?**

1. Гөлөгдэйбаатар.....
2. Фүжанжин.....
3. Шуну- Зорьсондо хүрэхийн тулд учирч болох эрсдэлийг тооцоолж, болгоомж хянуур ямагт хэрэгтэй, хэн нэгний буруу үйлээс олон хүний зорьсон хэрэг, эрх ашиг, эрүүл мэнд хохирч болохыг уншигчдад хэлэхийг хүссэн.

Сурагчийн нэр: .....

Эхэлсэн: ..... он ..... сар.....өдөр



**Дүр:** Зохиолын дүр нь тухайн зохиолын амин сүнс бөгөөд үүгээрээ урлагийн бусад төрлүүд, шинжлэх ухаанаас ялгарч, уран үгийн бүтээл туурвилын гол үүргийг гүйцэтгэж байдаг.

**Дүрийн холбоо хамаарал:** Нэг дүр нөгөө дүрийн нөлөөллөөс хамаарч тодорхойлогдохыг хэлж байна.

**Зөрчил:** Дүрүүдийн зорилгодоо хүрэхэд тулгарч буй саад бэрхшээл.

**Даалгавар**

**2 Дасгал 2**

**Б. Ринчений “Нууцыг задруулсан захиа” туурийг уншиж, дүрүүдийн холбоо хамаарлыг тогтооё.**

**Алхам 1. А. Зохиолын дүрүүдийг нэрлэнэ үү.**

|       |                 |           |
|-------|-----------------|-----------|
| Шуну  | .....           | .....     |
| хатан | Гэдөгдэй баатар | .....     |
| ..... | .....           | Фү жанжин |

**Б. Дүр бүрийн хоорондох холбоо хамаарлыг бичээрэй.**

|       |       |                 |           |
|-------|-------|-----------------|-----------|
| Шуну  | —     | .....           | .....     |
|       | ..... | .....           | .....     |
| хатан | ..... | Гэдөгдэй баатар | .....     |
|       | ..... | .....           | .....     |
| ..... |       | .....           | Фү жанжин |

Алхам 2. Гөлөгдэй баатар юуны төлөө манж жанжинтай дотноссон бэ?

.....  
.....

Миний бодлоор Гөлөгдэй баатрын зорьсон зорилго нь эцэг, хүү хоёрын

.....

.....

..... харилцаанаас мөн Шуну, элч хоёрын

.....

харилцаанаас болж үр дүнд хүрээгүй.

Алхам 3. Шуну элчдээ итгээгүйгээс үүдсэн хор уршгийг өөрийн бодлоор дэлгэрүүлэн тайлбарла.

✓ .....

✓ .....

✓ .....

Эдгээр бэрхшээлүүдтэй тулгарсан учир.....

.....

.....

Хэрвээ чи Шунугийн оронд байсан бол .....

.....

.....

Алхам 4. Гөлөгдэй баатрын гэр бүлийн харилцаанаас бие биедээ хандах хайр, хүндлэл, зан чанарыг зохиолч хэрхэн илэрхийлсэн бэ?

Тухайлбал: Эх хүү хоёр: Гөлөгдэйн хатан: -Эх хүн гэж байхгүй бол энэ ертөнцөд хүү хаанаас төрөх вэ? Гэнэн болгоомжгүй өсгөсөн нь эх миний л буруу .....хэмээсэн нь эх хүү хоёрын ариун нандин холбоо, хайр элбэрлийг харуулаад зогсохгүй эх хүний үрдээ “Үхтэл үр харам”, бүхнээ зориулдаг гэдгийг дүрслэн харуулсан байна.

Эцэг хүү хоёр: .....

.....

.....

Гөлөгдэй хатан хоёр: .....

.....

.....



**Зохиолын орчин:** Тухайн зохиолын үйл явдал хаана, хэзээ болж байгааг илэрхийлдэг. Орчин нь үйл явдал болж буй газар, орон байр, цаг улирал, цаг хугацаа, цаг агаарын байдал зэргээс бүрддэг.

**Нөхцөл байдал:** Дүрийн өсөлт, зан араншин, үйл хэрэг, сэтгэл санааны байдал амьдралын орон зай, зөрчил тэмцлийг өрнүүлж шийдэхэд тохирсон, уран сайхны аргаар бүтээсэн орчин ахуйн хүрээллийг хэлнэ.

**Даалгавар**

**3** Дасгал 1 Б, Ринчений “Нууцыг задруулсан захиа” туурийг уншиж Орчин, нөхцөл нь дүрийн зан төрх болоод зохиолын сэдвийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг тайлбарлая.

**Алхам 1. Зохиолын үйл явдал нь:**

A. Ямар улсын нутаг дэвсгэрт өрнөж байна вэ?

.....

B. Ямар нэртэй газар өрнөж байна вэ?

.....

C. Үйл явдал хэзээ болж байна вэ?

.....

Алхам 2. Төрсөн өдрийн найр эхлэх үеийн үйл явдлын орчны дүрслэлийг зураглаарай.



**Алхам 3. Зохиолын эхэнд Гөлөгдэй баатар болон манж Фү жанжны өргөө орчмын дүрслэлийг харьцуулан, дүрүүдийн зан чанарыг хэрхэн тодотгож байгааг нөхөж бичнэ үү.**

| Хэний?           | Өргөө орчмын орчны дүрслэл                         | Орчны дүрслэл нь зан чанарт хэрхэн нөлөөлж байна   |
|------------------|--|--|
| Гөлөгдэй баатрын | Фү жанжны өргөөнөөс өртөө хэртэй газар             | Дотроо бодолтой,<br>.....<br>.....<br>.....        |
| Фү жанжны        | .....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>..... | .....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>..... |

**Алхам 4.А.** “...Цэргийн бүрээ татаж, нам гүм болсон олон хүний нүд, баярт зориулж барьсан гоё эрээн асрын өмнө сөгдсөн дөрвөн хүний зүг ширтэн, манж цэргийн дарга, цаазын сумаар дохио өгмөгц Шуну эцгийн өмнө сөгдөн мөргөөд, өвдгөөс нь мөлхөн адис аваад босож сэлмээ далайн гялсхиймэгц өвгөн Гөлөгдэй баатрын толгой өнхрөн унав. Олон мянган хүний хөндий цээжнээс ганц хүн шиг санаа алдах чимээ сонсогдож эмэгтэйчүүд ханцуйгаараа нүүрээ халхалцгаав..”

**В.** “... Сэлмийн жур хийх чимээ гарч хатны толгой дэргэд нь өнхрөн ойчоод, чихэнд нь нэг юм хэлж байгаа юм шиг наалдан тогтов,,,” **ЗОХИОЛЧ ИЙМ** орчин, нөхцөл байдлыг сонгосноороо юу хэлэхийг хүссэн бол?

**А.** .....

.....  
.....  
.....  
.....

**В.** .....

.....  
.....  
.....  
.....




**Өгүүллэгийн утга санааг гаргахын тулд санааг хэрхэн хөгжүүлснийг дүгнэх**

Сурагчийн нэр: .....

Эхэлсэн: ..... он ..... сар.....өдөр



Сэдэв, санаа хоёр салшгүй холбоотой.



**Даалгавар**

**4** Дасгал 1 Ж.Лхагва “Эвэр” өгүүллэгийг уншиж ойлгоод сэдэв, гол санааг тодорхойлъё.

**Алхам 1. Зохиолыг яагаад “Эвэр” гэж нэрлэсэн бэ?**

.....  
 .....

**Алхам 2. Залуу тэх юуны төлөө амьдарч байна вэ?**

- A. Том эвэртэй болохын төлөө
- B. Сүргийн тэргүүн болохын төлөө
- C. Бусдыг айлган сүрдүүлэхийн төлөө


**Үүгээрээ зохиолч юу хэлэхийг хүссэн бэ?** .....

.....

**Алхам 3. Өгүүллэгээс юуг ойлгож, ухаарсан бэ?**

- A. ....
- B. ....
- C. ....

**Алхам 4. Б.Явуухулангийн “Тэхийн зогсоол” найраглалыг “Эвэр” өгүүллэгтэй харьцуулан сүргийн тэргүүн ямар байх талаар эргэцүүлэн өөрийн дүгнэлтийг бичээрэй. /Хариултын хуудаст “Тэхийн зогсоол” найраглалыг хавсаргав/**



Дууссан: .....он .....сар.....өдөр

**Өгүүллэгийг уншиж, соёл, түүх, нийгмийн хам  
сэдвийн хүрээнд мэдэрч, тусган хүлээж авах**

Уран зохиол 9

Сурагчийн нэр: .....

Эхэлсэн: ..... он ..... сар.....өдөр



**Өгүүллэг:** Нэг гол баатартай, эсвэл цөөн тооны туслах дүрээс бүтдэг. Гол төлөв баатрын амьдрал, үйл хэргийн нэг жижиг хэсэг, учрал тохиолдлыг өгүүлэх ба цаг хугацааны хувьд амьдралын нэгэн агшин хормыг харуулж, түүгээрээ хүн-нийгмийн утга чанартай анхаарал татсан эгзэгтэй нэг гол асуудлыг хөндсөн байдаг. (Д.Галбаатар Уран зохиолын нэвтэрхий толь)

**Даалгавар**

**5** Дасгал 1 Ж.Лхагва “Эвэр” өгүүллэгийг уншиж ойлгоод дасгалдаалгавраа ажиллая.

**Алхам 1. Өгүүллэгийн хэсгүүдээс сэтгэл хөдлөлийн ямар өнгө аяс илүү мэдрэгдэж байна вэ?**

Хүсэн хүлээсэн сэтгэл бүхий хэсэг .....

.....

Үл тоосон сэтгэл .....

.....

Уурлаж бухимдсан сэтгэл .....

.....

Хэсэгхэн ухаарсан сэтгэл .....

.....

**Алхам 2. Зохиолын гол хэсгээс янгир зөвхөн өөрийн хүсэлдээ автаж буруу үйлдэл гаргаж байгаа дүрслэлийг олж бичнэ үү.**

.....

.....

Энэ дүрслэлийн гол санаа бол.....

.....

.....

Дууссан: .....он .....сар .....өдөр

Алхам 3. Зохиолын ямар үг хэллэг, дүрслэл, өгүүлбэрийн утга санаа сэтгэлийг чинь хөдөлгөсөн бэ?

| Зохиолын хэл | Ямар үг хэллэг, дүрслэл, өгүүлбэр  | Сэтгэлийг чинь хэрхэн хөдөлгөсөн                             |
|--------------|------------------------------------|--|
| Үг хэллэг    | 1. Янгирын хууль<br>.....<br>..... | 1. Амьтад ч мөн хууль дүрэм байдаг байх нь<br>.....<br>..... |
| Уран дүрслэл | 1.<br>.....<br>.....               | 1.<br>.....<br>.....   |
| Өгүүлбэр     | 1,<br>.....<br>.....               | 1.<br>.....<br>.....   |

**Алхам 4. Зохиолыг бүхэлд нь өнгөөр илэрхийлбэл ямар өнгөөр илэрхийлж болох вэ? Яагаад ийм өнгөөр дүрсэлснээ дүгнэн бичээрэй.**

Жишээ нь .... Эх янгир бор шүдлэнг туурай гүйцэд хатаагүй юм хэмээн хамгийн хавцал талаас нь түшиж явлаа ... гэсэн өгүүлбэрийг би цагаан өнгөөр төсөөлж байна. Учир нь үрээ гэсэн эхийн хайр ямар үнэн, ямар агуу, уярам зөөлөн байдгийг энэ өгүүлбэрийн утгаас ойлгож байна.

Эхээ ольсон эврийн үзүүрт арьс үс шалбарч, дусал цус наалдаад байвч залуу янгирт анхаарч мэдэх зав байгаагүйг .....  
өнгөөр илэрхийллээ. Учир нь: .....

Дахиад хоёр тэх ногоон мөнгөний золиосонд одож, бор халиун сүргийн тэргүүнтэн болоход ганц хуруу дутаж байгаа үеийг .....  
өнгөөр илэрхийллээ. Учир нь: .....

Бусдын эвэр толгой тойрон ургаж, эсвэл дээшээ сэрийж байхад миний эвэр яагаад ..? хэмээн тэрбээр шаналан бодовч хариу олдохгүй байгааг .....  
өнгөөр илэрхийллээ. Учир нь: .....

Тархины бор хальс цоорох хоромд л “Миний эвэр буруу ургажээ” гэсэн там тумхан ухаарал янгирын толгойд нэг орж ирээд үүрд замхарсан нь шувуу суунгуут үргэн нисэхийн адил хэмээн дүрсэлснийг .....  
өнгөөр илэрхийллээ. Учир нь: .....

Эцэст нь зохиолыг бүхэлд нь ..... өнгөөр төсөөллөө. Учир нь: .....

Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар... өдөр



**Далд утга:** Энэ нь зохиолын өгүүлэмжээр шууд илэрдэггүй, тусгай судалгаа, тайлал тайлбар хийхийг шаарддаг. Уран зохиолд өнгөн талын ил дүрслэлээр дамжуулан ямар нэгэн утга санааг далдлан өгүүлсэн байдаг. Ил биш далд өгүүлсэн утгыг далд утга гэнэ.

**Хам сэдэв:** Бичвэрийн дотор үзүүлсэн орон, цаг болоод нөхцөл байдлыг хам сэдэв гэнэ. Эхийн санааг ойлгох явцад уншигч сонсогчдын дурдсан танил бус үгийн хэрэглээгээр илэрнэ.

Жишээ нь: нийгэм, соёл, түүх, шашин...

**Даалгавар**

6


Дасгал 1

**Д. Мягмарын “Үер” туужийг уншиж, зохиолын далд утгыг шинжилж, хам сэдвийн хүрээнд хэлэлцэн дүгнэе.**

**Алхам 1.** “...Их мөрний тохойн чийглэг хөрсөнд тэжээгдэн, тэнгэр өөд түмэн мөчрөө сарвайн ургаж, он жилийг элээхдээ амьдралын хатуу зөөлнийг ханатлаа эдэлсэн хөгшин буурал улиас...” **зохиолч зохиолоо энэхүү байгалийн дүрслэлээр эхэлсэн нь ямар учиртай гэж бодож байна вэ?**

.....  
 .....  
 .....

**Алхам 2.** Усч өвгөний хөгшин, залуу моддын тухай харьцуулан **бодлогоширч байгаа нь дүрийг тодруулахад ямар үүрэгтэй байна вэ?**



**Алхам 3. “...Ширүүн урсгалд орлоо. Төдий л холдоогүй байтал**

-За болохоо болилоо. Ус нь гарчихлаа гэж залуу шивэгнэв. Бүсгүйн аймшигт дуу үерийн усны шуугианд үл дарагдана. Өвгөн эргэж ч харсангүй. Оволзож хөвж яваа завиа хүчлэн сэлсээр...” гэсэн дүрслэлд яагаад заавал ширүүн урсгал дунд бүсгүйг амаржуулсан бэ? Үүний цаана ямар далд утга байгааг таамаглаарай.

.....  
.....  
.....  
.....  
.....

**Алхам 4. Гүн ухаан, орчлонгийн жам ёс, ёр бэлгийн хам сэдвийг хэрхэн хөндсөн төдийгүй зохиолд ямар үүрэгтэй байна вэ?**

| Гүн ухаан  | Орчлонгийн жам ёс   | Ёр бэлэг  |
|--|---|---|
| <p><b>Эшлэл</b></p> <p>Эх хүү хоёрыг холбож байгаа тэр нарийхан хүйг огтлох юм даанч ухаанд нь орохгүй байв...</p> | <p><b>Эшлэл</b></p> <p>...Завинаасаа үсрэн бууж амьсгаадан хэд алхсанаа үерийн усанд орвонгоороо булгаран ойчих хөгшин улиас мэт намаг шавар дунд намсхийн унав...</p>                              | <p><b>Эшлэл</b></p> <p>...Завинаасаа үсрэн бууж өвгөний дэргэд харайлган хүрээд босгох гэж өрөөсөн гараараа өргөхөд нялх хүүхдийн час хийх дуу дахин хадав...</p> |
| <p><b>Утга, үүрэг</b></p> <p>.....<br/>.....<br/>.....<br/>.....<br/>.....<br/>.....<br/>.....</p>                 | <p><b>Утга, үүрэг</b></p> <p>Усч өвгөний хүний хорвоог орхиж байгаа үйлийг орвонгоороо булгаран ойчих хөгшин улиастай адилтгасан нь зохиолын гол санааг тодруулахад чухал үүрэгтэй дүрслэгджээ.</p> | <p><b>Утга, үүрэг</b></p> <p>.....<br/>.....<br/>.....<br/>.....<br/>.....<br/>.....<br/>.....</p>  |

**Уран дүрслэлийн учир холбогдлыг нарийвчлан шинжлэх**

Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар.....өдөр



**Уран дүрслэл:** Хэлний нэгжүүдийн шилжмэл салаа утгыг дүрслэх ур маяг гэнэ. Уран дүрслэх арга хэрэгсэл болсон зүйрлэл, адилтгал, төлөөлөл, ихэсгэл, багасгал, ёгтлол, егөөдөл зэрэг яруу хэрэглүүрийг чөлөөтэй ашигладаг.

**Өчил:** Баатар тайван амгалангаар тунгаан бодох, сэтгэл эргэж хөрвөх, учраа олохгүй самгардалд орох, сандран тэвдэх, харамсах, уйтгарлах, санагалзах, бодлогошрох зэрэг сэтгэл хөдлөлийг илэрхийлнэ.

**Даалгавар**

7 Дасгал 1 Д. Мягмарын “Үер” туужийг уншиж, уран дүрслэлийн учир холбогдлыг нарийвчлан шинжлэе.

**Алхам 1. Зохиолд хэний, юуг зэс шиг улайн минчийсэн хэмээн дүрсэлсэн бэ?**

A. Өвгөний хуруунууд B.

Бүсгүйн царай

C. Өвгөний хэнхдэг

D. Хүүгийн хүй

Алхам 2. Дэнзэн өвгөний хэлсэн үг, дотоод яриа, өчил яриануудыг ажиглан зохиолч үүгээрээ юу хэлэхийг зорьж байгааг таамаглан бичээрэй.

| Хэлсэн үг   | Дотоод яриа /бодол санаа/   | Өчил яриа   |
|---|---|---|
| Уул нь би гучин алд нэмсэн гэж итгэж байсан юм. Гэтэл гучин нэгэн алд...            | Би одоо гурван хүний амийг дааж явна шүү. Хүн гэдэг чинь ингэх л гэж...чухам ингэх л гэж амьд явдаг юм байна. | Хүн гэдэг чинь даанч богино настай амьтан юм уу даа?...                             |
| Юу хэлэхийг зорьсон?<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>..... | Юу хэлэхийг зорьсон?<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....                           | Юу хэлэхийг зорьсон?<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>.....<br>..... |

**Алхам 3. Усч өвгөний гадаад төрхийг ямар үг сонгон, хэрхэн дүрсэлснийг, энэ дүрслэлээр юу хэлэхийг зорьсон болохыг өөрийн бодлоор тайлбарлана уу.**

| Юуг?                | Уран дүрслэл  | Зохиолч юу хэлэхийг зорьсон  |
|---------------------|---|--|
| Бие, гар, хөл       | Бие: Нар шингэх үеийн модны сүүдэр шиг тахир агаад нэн өндөр<br>Гар:.....<br>.....<br>Хөл: .....<br>..... | Өтөлсөн, бөгтөр нуруутай, өндөр биетэй,<br>.....<br>.....<br>..... |
| Эрүү, үс, нүд       | Эрүү.....<br>.....<br>Үс.....<br>.....<br>Нүд.....<br>.....   | .....<br>.....<br>.....<br>.....<br>.....                          |
| Хэнхдэг, далны маяа | Хэнхдэг.....<br>.....<br>Далны маяа.....<br>.....   | .....<br>.....<br>.....<br>.....                                   |
| Дотоод сэтгэл       | .....<br>.....<br>.....   | .....<br>.....<br>.....  |

**Алхам 4. “ Хоёр ясан сарвуугаараа ч гэсэн сэлж байгаад усны цаана гаргана” Өвгөнөөр яагаад заавал ийм үг хэлүүлсэн бэ?**

.....  
 .....  
 .....  
 .....

**Энэ нь дараагийн үйл явдалтай хэрхэн холбогдож байна вэ?**

.....  
 .....  
 .....  
 .....

Дууссан: .....он .....сар..... өдөр

**холбоо хамаарлыг тайлбарлах**

Сурагчийн нэр: .....

Эхэлсэн: ..... он ..... сар ... өдөр

**Өгүүлэгдэхүүн /үйл явдал/-ий бүтэц:**

**Эхлэл-** Зохиолын өгүүлэгдэхүүний зөрчил үүсэх суурь дэвсгэр бүхий үйл явдал.

**Зангилаа-** Зохиолын үйл явдал үргэлжлэх, зөрчил мөргөлдөөн, үүсэх шалтгаан.

**Өрнөл-** Зохиолын зангилаанаас учир шалтгааныг олохын тулд цааш үргэлжилж байгаа хэсэг.

**Туйл-** Зохиолын үйл явдал, зөрчил тэмцэл хурцдаж туйлдаа хүрэх хэсэг.

**Тайлал-**Зохиолын зөрчил тэмцэл туйлдаа хүрч улмаар хэрхэн шийдэгдэж байгаа хэсэг.

**Төгсгөл-** Зохиолын төгсгөлд баатруудын хувь заяа ямар болсон, зохиолч өөрөө хэрхэн үзсэн зэргээ илэрхийлснийг хэлнэ.

8 Дасгал 1 Ч. Лодойдамбын “Алтайд” романыг уншиж, зохиолын үйл явдлын холбоо хамаарлыг тайлбарлая.

T1 Алхам 1. Дамдингийн нагац ахынхаа тухай ярьсан яриаг зохиолч яагаад оруулсныг, энэ нь цааш ямар үйл явдалтай хэрхэн холбогдож байгааг тайлбарлаарай.

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

**Алхам 2. Зохиолд өнгөрснийг дурссан , өгүүлсэн ямар амьдрал, хэрэг явдал гарч байгааг зохиолоос эш татна уу. Жишээ нь: “...1909 онд, миний нагац ах Ням, нутгийн хэдэн хүмүүстэй хамтран жин тээхээр Хөх хот руу аялжээ...” гэх мэт.**

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

**Энэ нь зохиолд ямар үүрэг гүйцэтгэж байна вэ?**

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....



**Алхам 3. Зохиолд ирээдүйг зөгнөсөн , өгүүлсэн ямар амьдрал, хэрэг явдал гарч байгааг зохиолоос иш татна уу. Жишээ нь: “... Гэвч энэ удаагийн шинжилгээнийхэн тааварлаж чадаагүй бол дараагийн шинжилгээнийхэн эрт орой боловч заавал тайлбарлах нь дамжиггүй...” гэх мэт.**

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Энэ нь зохиолд ямар үүрэг гүйцэтгэж байна вэ?

.....

.....

.....

.....

.....

.....

**Алхам 4. А. Эрдэнэ, Бат, Төмөр 3 юмаа хайгаад олохгүй мухардаж худаг руу явж байгаа нь цааш өрнөх үйл явдалтай хэрхэн холбогдож байна вэ?**

.....

.....

.....

.....

.....

.....

.....

**Б. “Алтайд” романы үйл явдлууд хоорондоо ямар зөрчлүүдээр холбогдож байгааг тогтоон тайлбарлаарай. /Хэний ямар үйлдэл, үг яриа, үзэл бодлоос болж өөр хэн нэгний амьдралын шугам өөрчлөгдөж байгааг ялган тодорхойлох, хэрвээ ийм үйл явдал болоогүй бол тухайн дүрийн амьдралын шугам өөрчлөгдөх байсан уу? гэдэгт дүгнэлт хийгээрэй/**

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Хүүрнэл зохиол

Үнэлгээ

**1. Зохиолч “Эвэр” өгүүллэгийн үйл явдлыг хэрхэн өрнүүлэв?**

А. Эхээс мэндэлсэн янгирын бор ишиг Б.

Толгой дээр нь хоёр газар товойж

В. ....

Г. ....

Д. ....

**2. Залуу янгирын дүрийн зорилгыг тодорхойлон бичнэ үү.**

.....  
.....

**3. Гөлөгдэй баатар Фү жанжинтай учир битүүлэг ойртон нөхөрлөсөн нь**

А..... давуу талтай байсан.

Б..... сул тал болсон.

**4 , “Алтайд” романы тавдугаар хэсгийн “ уулын цаад талд өндөр биш**

ажээ. Хормойноос нь цааш маш өргөн талбай үргэлжлэн харагдана. Талбайн энд тэнд нь хэдэн мянган жил халуун наранд шарагдсанхүрэн хар хад сүндэрлэн харагдана

..... ” гэсэн орчны дүрслэл нь цааш өрнөх үйл явдалтай хэрхэн холбогдож байна вэ?

.....  
.....  
.....

**5. Үер туужийн төгсгөлд “ Орчлон ертөнц түм буман жил эргэлдсэн**

**хуучин замаараа тэнхлэгээ тойрон эргэсээр” хэмээх дүрслэл нь зохиолын гол санаатай хэрхэн холбогдож байна вэ?**

.....  
.....  
.....

**6. “Нууцыг задруулсан захиа” туурийн Шунугийн отгон дүүгийн “ Энүүгээр цавчаарай. Хатиг битгий хөндээрэй гэж гараараазааж**

**хэлсэн нь амьсгаагаадарж, чимээ аниргүй байгаа олонд тов тодорхой сонсдон зурхийг шөвгөөр чичих шиг болов.”** тодруулсан дүрслэл ямар уран дүрслэл болохыг тодорхойлон утгыг тайлбарлаарай.

.....  
.....  
.....